



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/449

Чингис хот

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 58 дугаар зүйлийн 58.2.20, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2021 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан болон нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн чанар, үр дүнгээр Эрүүл мэндийн газрын дарга нь хангалттай буюу "А" /96%/ үнэлгээ авсан тул Эрүүл мэндийн сайдын 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн А/567 дугаар тушаалыг үндэслэн урамшуулал олгосугай.

2. Батлагдсан төсөвтөө багтаан, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн урамшуулал олгохыг Эрүүл мэндийн газрын нягтлан бодогч (Ц.Алтан-Өлзий)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Г.Лхагвахаган)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231012111